

**УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” ХНН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Улаанбаатар төмөр зам” /УБТЗ/ хувь нийлүүлсэн нийгэмлэг /ХНН/-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 тоот тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“УБТЗ” ХНН-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 93.3 хувьтай байна.

2.1. “УБТЗ” ХНН-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 58 арга хэмжээ туссан бөгөөд 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй
		100	90	70	50	30	0	
58	93.3	47	2	5	3	1	-	-

2.2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Зам, тээврийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг суурь түвшинтэй нь харьцуулан /томьёоны дагуу/ гаргасан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)						
		100	90	70	50	30	13.3	
2	6.6	-	-	-	-	-	1	1

2.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Эрхзүйн актын нэр	Нийт заалт	Хэрэгжилт (хувиар)	Үүнээс (хувиар)				Хугацаа болоогүй
			100	70	30	0	
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	1	0	-	-	-	1	-
УИХ-ын тогтоол	2	100.0	2	-	-	-	-

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	9	88.9	7	1	1	-	-
Дүн	12	83.3	9	1	1	1	-

1.4. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)				
		100	70	30	0	Хугацаа болоогүй
40	100.0	40	-	-	-	-

1.5. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)				
		100	70	30	0	Хугацаа болоогүй
8	100.0	8	-	-	-	-

1.6. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн төрөл	Хэрэгжилтийн дундаж хувь	Тайлант хугацаанд байршуулсан (хувиар)	Хугацаа хоцроож байршуулсан (хувиар)					Хугацаа болоогүй (төрлийн тоо)	Оруулах мэдээлэлгүй
				100	90	70	50	30	0		
1	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	4	100.0	3	-	-	-	-	-	-	1
2	Бусад	3	100.0	2	-	-	-	-	-	-	1
Дүн		7	100.0	5	-	-	-	-	-	-	2

1.7. Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Хэрэгжүүлэх үзүүлэлтийн тоо	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс /хувиар/				
				100	70	30	0	Хамааралгүй
1	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	78.7	6	-	1	1	2

2	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	83.3	4	1	1	-	-
3	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	95.00	5	1	-	-	9
4	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	100.00	1	-	-	-	1
5	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	65.00	2	-	2	-	9
Дүн		46	82.4	18	2	4	1	21

Гурав. Дүгнэлт:

I. Төлөвлөлтийн байдал

1. “УБТЗ” ХНН-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн саналыг тусган хэрэгжүүлэх арга хэмжээний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг боловсруулсан боловч бодлогын баримт бичигт туссан арга хэмжээний зорилтот түвшнийг зөрүүтэй төлөвлөхөөс гадна заримыг нь орхигдуулсан байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан тус байгууллагын хариуцан хэрэгжүүлэх Улаанбаатар төмөр замын гол замд 200 км их засвар хийнэ гэсэн арга хэмжээний зорилтот түвшин нь 50 км-т их засвар хийнэ гэсэн байхад “УБТЗ” ХНН-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 27 км-т их засварын ажил хийж гүйцэтгэнэ гэж тусгасан. Энэхүү ажлыг 2023 онд 27 км-т их засвар хийхээр мөн л дутуу буюу гүйцэтгэх ажлаа багасган төлөвлөж байсан.

- Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Зам, тээврийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд туссан Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх /269 км хос замын оруулга/ гэсэн ажлыг тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгалгүй орхигдуулсан байна.

2. Зам, тээврийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус байгууллагын хэрэгжүүлэх 12 арга хэмжээ туссан байх бөгөөд 2 арга хэмжээг “УБТЗ” ХНН-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө хэд хэдэн арга хэмжээ болгон нарийвчлан төлөвлөжээ.

II. Хэрэгжилтийн байдал

1) Тус байгууллага нь нь 2024 онд үйл ажиллагаандаа нийт 173 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласнаас 100 хувийн үнэлгээтэй 127, 90 хувийн хэрэгжилттэй 2, 70 хувийн хэрэгжилттэй 8, 50 хувийн хэрэгжилттэй 3, 30 хувийн хэрэгжилттэй 6, 13.3 хувийн хэрэгжилттэй 1, тасарсан буюу хэрэгжүүлээгүй 3, хамааралгүй 21, оруулах мэдээлэлгүй 2 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт дунджаар **91.9** хувьтай байна.

2) “УБТЗ” ХНН 2024 онд 33,2 сая.тн ачаа тээвэрлэсэн нь 2023 оны жилийн эцсийн ачаа тээврээс 2.9 сая.тн ачаагаар илүү тээвэрлэсэн үзүүлэлттэй байна.

3) Харин 2023 онд 2,141,800 зорчигч тээвэрлэж 89.2 хувь, 2024 онд нийт 1,990,000 зорчигч тээвэрлэж 79.6 хувийн хэрэгжилттэй ажиллажээ.

4) Замын-Үүд-Эрээн хилийн төмөр замын боомтоор хоногт дунджаар өргөн царигийн төмөр замаар 16 галт тэрэг хүлээлгэн өгч, нарийн царигийн төмөр замаар хоногт дунджаар 8.0 галт тэрэг хүлээн авахаар төлөвлөснөөс:

Хүлээн авсан:

Өргөн царигаар хоногт дунджаар 15.46 галт тэрэг

Нарийн царигаар хоногт дунджаар 7.23 галт тэрэг

Хүлээлгэн өгсөн:

Өргөн царигаар хоногт дунджаар 15.44 галт тэрэг.

Нарийн царигаар хоногт дунджаар 7.27 галт тэрэг хүлээлгэн өгснөөр өргөн царигийн галт тэрэг солилцоо 96.6%, нарийн царигийн галт тэрэг солилцоо 90.6% хүрч ажилласан байна.

5) Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Зам, тээврийн сайдын хариуцан хэрэгжүүлэх 2 арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй хэрэгжүүлж ажиллажээ. Харин урт болон дунд хугацаанд хэрэгжүүлдэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хурдасгаж, зохион байгуулалтыг сайжруулах, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаануудыг тодорхой болгоход чиглэсэн Зам, тээврийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгавруудыг хангалттай хэрэгжүүлсэн байна.

6) ЗГҮАХ-т туссан 2024 онд Улаанбаатар төмөр замын гол замд 50 км их засвар хийх арга хэмжээний хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн байх бөгөөд тус бодлогын баримт бичгийн зорилтот түвшинтэй ижил төлөвлөөгүй, багаар буюу 27 км гол замд их засвар хийхээр өөрийн байгууллагын төлөвлөгөөнд тусгасан хэвээр байна.

7) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.3, 1.7, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.11, 5.1, 6.2-т туссан арга хэмжээг хоёр улирал дараалан хангалтгүй хэрэгжүүлжээ.

8) “УБТЗ” ХНН-ийн 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн дөрвөн зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй хэвээр байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Зам, тээврийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан өөрийн байгууллагын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг “УБТЗ” ХНН-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж, зорилтот түвшнийг ижил төлөвлөх,

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, байгууллагын цахим сайтад ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг цаг тухайд нь байршуулан хөгжүүлэлт хийхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг ханган ажиллах;

- Биелэлтийг монгол хэлний зөв бичгийн дүрмийн алдаагүй, тодорхой, ойлгомжтой, зорилтот түвшинд уялдуулж ажлын үйл, явц тоочилгүй тайлагнаж хэвших;

- Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, төлөвлөлтийг зөв тодорхойлж, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Зам, тээврийн сайдын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа, хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь уялдуулж, тайлагнаж хэвших;

2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжилтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь харьцуулж, хэрэгжилтийг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

3. Тээврийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ачаа, зорчигч тээврийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах ажлыг эрчимжүүлэх;

4. БНХАУ-ын эрх бүхий байгууллагаас олон улсын галт тэрэг аялуулах зөвшөөрөл авч, Улаанбаатар-Бээжингийн чиглэлийн олон улсын зорчигчийн галт тэрэгний аяллыг сэргээх;

5. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан өөрийн байгууллагын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг “УБТЗ” ХНН-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж, зорилтот түвшнийг ижил төлөвлөн, хэрэгжилтийг хангах;

6. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Зам, тээврийн сайдын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлэх /269 км хос замын оруулга/ төслийг эхлүүлэх гэсэн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэн, бодит ахиц гаргах;

7. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой бодлогын баримт бичиг болон журам шинэчлэн боловсруулах, сургалт зохион байгуулах ажлыг эрчимжүүлэн төлөвлөсөн ажлаа цаг тухайд нь гүйцэтгэж, зорилтот түвшинд хүргэх, (6.3, 8.2, 8.5);

8. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төрийн үйл ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй, хүнд сурталгүй, авлигаас ангид байлган, нийгэмлэгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн, бүрэн байршуулж, хэрэгжилтийг хангах;

9. Хэрэгжүүлэхэд хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүй тогтмол хийгддэг, хууль тогтоомжоор үүрэг болгосон, байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах ажлыг бүрэн хэрэгжүүлэх;

10. Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа, хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь уялдуулж, зөв бичгийн алдаагүй, хоёр мянган тэмдэгтэд багтаан, ажлын явц биш үр дүнг тайлагнаж хэвших;

11. “УБТЗ” ХНН-ийн цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө бүрэн тусгаж, төлөвлөлтийг зөв тодорхойлон, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР